

## ЯПОН ТЭНГИСИЙН ЭРЭГ ХАВИЙН НУТГААР

### Ч. Далай

Миний бие 1995 онд Японд анх удаа очиж үзсэн бөгөөд тэгэхдээ бүр урт богино хугацаагаар дараалан гурван удаа явсан юм. Бас гайхалтай нь очих бүрдээ Япон тэнгисийн эрэг хавийн нутгаар уригдан зочилсон билээ. Дэлхийн газрын зураг дээр Япон тэнгис буюу Японоор Нихон кай гэж нэрлэсэн энэхүү үзэсгэлэнт хөх цэнхэр тэнгис нь Номхон дөлгөөн далайн хагас түгжигдмэл тэнгис юм. Баруун талаараа Европ—Азийн эх газар, зүүн талаараа Сахалин Хоккайдо, Хоншю, Шикоку, Кюшюү арлуудын дунд оршдог. Хойд талаараа Невельск, Лаперузын хоолойгоор Агнурын тэнгистэй, зүүн талаараа Цугарын хоолойгоор Номхон далайтай, өмнө талаараа солонгосын хоолойгоор дорнод хятадтай тус тус хиллэдэг байна. Солонгосчууд Япон тэнгисийг зүүн тэнгис гэж нэрлэнэ. Япон тэнгис нь 978 000 км талбайтай усны гүний дундаж нь 1752 м юм. Япон тэнгис нь Японоос гадна ОХУ, Солонгосын нутгийн эрэг хавийг тэтгэн угааж оршдог ажээ.

Япон тэнгисийн эрэг нь үзэсгэлэнтэйгээс гадна нэлээд уулархаг шинжийг хадгалсан өндөр, огцом эгц цохионы байдалтай бөгөөд ёроол нь 4036, 4226 м-ийн гүнд тогоо хэлбэртэй харагддаг байна.

Япон тэнгис нь далайн зөөлөн урсгал бүхий уур амьсгалтай. Өвлийн цагт азийн эх газрын хүйтэн хуурай агаарыг авчирдаг, салхины хурд хүч ихэнхдээ 4—6 буюу 5—12 м/сек байдаг байна. Зүүн хойд хэсгээрээ далайн давалгаа шуурга нэлээд ихтэй. Далайн шуургын давтамж нь 5%-д хүрдэг. Зуны улиралд далайгаас ирэх дулаан чийглэг агаар бүхий зүүн өмнөд зүгийн муссон салхитай байдаг. Зуны улиралд салхины хүч 3 балл буюу 4 м/сек хүртэл багасдаг учир далайн шуурга нэгэн адил татардаг ажээ. Жил бүрийн 5 сараас 10 сарын хооронд далайн хар салхи (тайфун) үүсэх цаг юм. Зарим үед далайн хар салхи үүсэхдээ эрэг хавийн газрыг их хэмжээгээр эвдлэн сүйтгэдэг ч удаатай. Далайн хар салхи ихэвчлэн зүүн, зүүн өмнөд хэсгээр их гардаг бөгөөд давтамж нь сард 1—2 удаа ч тохиолддог ажээ. Харин тэнгисийн баруун хойд хэсгээр далайн хар шуурга үргэлж гарахгүй бөгөөд дундачаар дөрвөн жилд нэг л удаа болох жишээтэй юм. 2-р сарын дундаж температур хойд хэсгээрээ —15 градус, өмнөд хэсгээр +6 байдаг бол 8-р сард хойд талаар +17, өмнөд +25 градус байдаг байна. Жилийн дундаж хур тундас зүүн хойд хойд хэсгээр 310—500 мм-ийн хооронд хэлбэлздэг бол зүүн өмнөд хэсэг Хоншю арлын эрэг хавиар 1500—2000 мм хүрдэг ажээ. Зун цагт хамгийн их хур тундас унадаг бөгөөд хаврын сүүлч, зуны улиралд байнга манантай байдаг.

Япон тэнгисийн гадаргуугийн урсгал нь циклон маягийн эргүүлэг үүсгэдэг. Тэнгисийн хойд хэсгээр урсгалын хурд цагт

\*Ч. Далай. ЗХАТ-ийн захирал, академич, доктор, профессор

1 км байдаг бол зарим газраар цагт 3 км хүрдэг байх жишээтэй. Цусимагийн урсгал гэж байх бөгөөд тэрхүү урсгал нь жилд дундажаар  $57405 \text{ км}^3$  ус авчирдаг ба энэ нь Япон тэнгисийн цаг уурын дулааны тэнцвэрт ихээхэн нөлөөлдөг юм байна. Япон тэнгисийн усны өнгө нь цэнхэр, ногоовтор цэнхэр бөгөөд тунгалаг нь 10м орчим байдаг. 11-р сард тэнгисийн хойд хэсгээр болон булан тохой боомт газруудаар мөстөж тэр нь ихэнх газраар 3,4 сар хүртэл үргэлжилж харин хойд хэсгээр бүр 5-р сар хүртэл хайлахгүй хэвээр байдаг байна.

Тэнгисийн амьтны ертөнц нь хойд урд хэсгээрээ харилцан адилгүй. Хойд хэсгээр хүйтэн усанд дассан төрөл бүрийн усны амьтад (загас) байхад Урд талаар нь дулаан усанд зохицсон амьтад байх жишээтэй. Тэнгисийн зарим хэсгээр хазяа нэг халим загас орж ирдэг гэдэг.

Япон тэнгис нь далайн тээвэрт нэн онцгой үүрэгтэй бөгөөд Япон, ОХУ, Солонгос, АНУ, БНХАУ зэрэг улсуудыг номхон далайн бусад улс оронтой холбож өгдөг байна. Япон тэнгисийн эрэг хавиар загасны үйлдвэрлэлийн том том үйлдвэрүүд төвлөрсөн байдаг. Япон тэнгисийн гол боомтууд дээр дээр усан хөлөг онгоц барих буюу хөлөг онгоц засварлах үйлдвэрүүд байдаг ажээ.

Өөрийнхээ явж үзсэн тухайгаа өгүүлэхийн өмнө Япон тэнгисийн тухай ийнхүү товчхон танилцуулга хийв. Ер Япон тэнгис бол цэвэр үзэмжтэй, тунгалагдуу устай, баялаг ихтэй, үзэсгэлэнтэй далай юм. Япончууд энэхүү далайгаараа баярхаж түүнийгээ цэвэр цэмцгэр байлгаж экологийн тэнцвэрийг хадгалах талаас нь ихэд анхаарч янз бүрийн ажил хөдөлмөр өрнүүлдэг ажээ.

Япон тэнгистэй Японы Хоккайдэ, Хоншю, Шикоку, Кюшюү дөрвөн арал бүх талаараа нягт холбоотой бөгөөд уг тэнгисийн Японы талын үйл ажиллагаа голдуу энэ дөрвөн арал хавийн бүс нутгаар л явагдана.

1995 оны 2-р сард Ниигата хотод болсон Зүүн хойт Азийн зургаан улсын төлөөлөгчдөөс бүрдсэн олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд академич Б. Балдоо нарын хэдэн эрдэмтэнтэй цуг уригдан оролцсон юм. Ниигата хот бол яг Япон тэнгисийн эрэгт орших бөгөөд Япон тэнгисийн экологийг хамгаалахад, тэр талаар судалгаа шинжилгээний ажил хийж ном өгүүлэл бичиж нийтлүүлсэн, санаа тавьсан эрдэмтэн бичгийн хүмүүс болон байгууллагад жил бүр тусгай шагнал олгодог журамтай ажээ. Биднийг бага хуралд оролцож байх үеэр 1994 оны шагнал гардуулах ёслол болж тэрхүү тусгай шагналыг хоёр хувь хүн нэг байгууллагад хүртээв. Уг шагналыг авсан эрдэм шинжилгээний байгууллага нь Оросын ШУА-ийн Алс дорнодын хүрээлэн байлаа. Бид ч баяртай байв. 1995 оны шагналыг АНУ-ын Хавайн арал дахь Өрнө дорнын төвийн захирал бидний сайн танил эрдэмтэн Ли Жей Чо авсан байна. Бид Ниигата хотод байхдаа Ниигата усан боомтыг үзсэн юм. Яг л Япон далайн эрэг дээр баригдсан маш том, гоёмсог орчин үеийн тоног төхөөрөмжтэй усан боомт хот байв. Тэр үед Ниигата хотод цас орж байгалийн үзэсгэлэн нэн төгөлдөр, сэтгэл татам сайхан байгаль харагдаж байсан билээ. Чухам ингэж Ниигатагийн сайхан цагаан будаа идэж амттай загасны шөлийг нь ууж Япон тэнгисийн эргээр явж «ямар сай-

зүүн хошуу дээр «Монгол тосгон» нэртэй 20 гаруй монгол гэр барьсан жуулчны бааз байгуулжээ. Би энд зочилж байхдаа Япон айлд анх удаа хонож үзэв. Кюшюү их сургуурийн профессор Морикава түүний гэргий Харухи нар намайг гэртээ гурав хонуулж маш сайхан зочлуулав. Япон эмэгтэй хүний хан далай вэ» гэдэг анхны сэтгэгдэл төрсөн мань ийм билээ.

Хоёр дахь удаагаа надад мөн оны 5-р сарын 10-наас 9-р сарын 10 хүртэл бүтэн 4 сар Японд байх завшаан олдсон юм. Япон фондын шугамаар уригдан очиж Осака хотын олон улсын харилцааны их сургуульд эрдэм судлалын ажил хийв. Мацуда Кой—ичи гэдэг профессор. Мацукава гэдэг монгол хэл сайн мэддэг залуу эрдэмтэн хоёртой хамт ажиллав. Тэнд байхдаа «Монгол Японы түүхэн харилцааны зарим асуудалд: (Юан гүрний цэрэг Японы довтолсон) тухай» хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэл бичив. Гэвч би энэ удаа тэнд ажилласан эрдэмийн ажлынхаа тухай бичих гэсэнгүй, зөвхөн Япон тэнгисийн эргээр хоёр дахь удаагаа явсан сэтгэгдлээ цөөн үгээр хэлэхийг хичээв. 1995 оны 7-р сарын 24—27 хүртэл Кюшюү бүс нутгийн Хакадагийн буланд очиж үзэв. Эртнээс нааш хүсч хүлээсэн мөрөөдөл мань биелэв. Би Хакада-д очъё гэжүнэхээр их боддог байсан. Япон тэнгисийн эргийн энэхүү үзэсгэлэнт булан тохойг үзэж түүнийг тойрон явахад үнэхээр сэтгэл хөдөлж байлаа. Сэтгэл хөдлөх нь хоёр талтай байх. Кюшюүгийн төв нь сая 300 мянган хүн амтай Фуку Ока хот юм. Энэ хот нь түүхэнд Хакада хот гэж гардаг бөгөөд Япон тэнгисийн зүүн үзүүрийн эрэг дээр баригдсан зам харилцааны том уулзвар ажээ. Кюшюү бүс нутаг бол түүхээс Японы гадаадтай харилцах усан замын гол зангилгаа болж байсан. Энэ бүс нутаг ялангуяа Хакадаан булан, Такашима арал монголын түүхтэй нэн их холбоотой. Хубилай хаан 1266 оны 11-р сараас 1275 оны 3-р сар хүртэл Японы эзэн хаанд 5 удаа элч зарсан бөгөөд цөмөөрөө л Кюшюү нутгаар хүч очдог байжээ.

1274 оны намар Хубилай хааны зарлигаар Юан гүрний 900 том жижиг онгоцтой 25000 цэрэг монгол жанжин Шиндуугийн удирдлагаар Японыг довтолж Хакада булангийн эргээр дайтаж байгаад далайн хар шуурганд өртөж цэргийн ихэнх нь далайд живсэн билээ. Тэрхүү Далайн хар салхи үүссэн газрыг, монгол цэргийн байлдаж явсан далайн эрэг орчмын газрыг ажиглахад Монголын түүхч хүний хувьд өөрийн эрхгүй гунигийн сэтгэл төрөгдөж байв. «Түрэмгий дайн гэдэг ийм л үр дагаварт хүргэдэг» гэж бодоод л хөөрхий тэр усанд живсэн монгол идэр эрсийг сэтгэлдээ бодон, нүдэндээ доголлон нулимастай гашуудаж л явлаа. Далайд живсэн монгол цэргийн цогцсыг бунхалсан хөшөө Хакада булангийн «Шигано шима» гэдэг өнчин арлын нэгэн хадан хошууд байдаг ажээ. Мөн далайн эрэг дээр «Монгол уул» нэртэй уул ч байна.

1275 онд Хубилай хааны илгээсэн Туушин тэргүүтэй таван элч мөн энэ нутгаар хүрч иржээ. 1275 оны 9-р сарын 7-ны өдөр тэднийг Японы самурайн толгойлогч Токимунэ-гийн тушаалаар цаазалсан бөгөөд тэдний цогцсыг оршуулсан хөшөө Камакура хотын Жорижи гэдэг сүмийн дотор байна. 1281 онд Хубилайн илгээсэн 140,000 их цэрэг Японыг хоёрдахь удаагаа довтолж бас далайн хар салхинд өртөж ихэнхи нь живсэн юм. Усанд

живсэн монгол цэргийн дурсгалын хөшөө Такашима арал дээр босгосон байна. Такашима арал дээрээс Япон тэнгисийг ажиглахад үнэхээр гайхалтай сайхан. Далайн хар шуурга болсон далай дотроос Монголын түүхтэй холбоотой их л эд өлгий олддог юм байна.

Монгол цэрэг анх гарч ирж байлдсан тэр Такашима арлын ажиглалтаг чанар, хүүхдүүд нь эцэг эхээ хүндэлдэг байдал зэргийг энэ айлгаас үзэв.

Дараа нь мөн Япон далайн эрэг дагасан үзэсгэлэнт нутаг Фукуи нутаг, түүний төв хот Обамад очсон нь Япон тэнгисийн эргээр гурав дахиа явсан хэрэг юм. Тэнд, 700 жилийн түүхтэй Муоцужи, Эйхэжи хоёр сүм үзэв. Өндөр уул дээр буй Муоцужи сүмд хүрэхэд 132 чулуун шатаар өгсөж очно. Ер нь энэ Обама хотод маш олон сүм хийд байх бөгөөд тэдгээрийн дотор их эртний түүхтэй сүм ч олон байдаг ажээ. Далайн эрэг дээр буй «сотомо савэ» хэмээх маш гоёмсог байгалийн хадан цохио байна. Тэнд очиход Япон тэнгисийн эргийн нэгэн гайхамшиг болох нь үзэгдэнэ. Бас таван нуур гэж байх бөгөөд гурав нь далайн шорвог ус, хоёр нь цэнгэг устай юм. Яахаараа яг ижилхэн таван жижиг нуур хоёр янз байдаг нь бас л байгалиас заяасан ер бусын үзэгдэл гэлтэй. Энд усанд ороход маш сайхан элстэй далайн эрэг байна. Эргийн дагуу хэдэн мянган хүн усанд сэлж наранд шарж байв. Япон тэнгис гэдэг Япон хүнд жаргал өгдөг юм байна гэж бодогдов. Тэнд жил бүрийн зуны улиралд сая таван зуун мянган хүн усанд сэлж амарна.

Мөн оны 10-р сард би Хокайдогийн төв Саппура хотод очиж Зүүн хойт Ази судлалын олон улсын хуралд оролцож илтгэл тавьсан. Бас л тэндэхийн Япон далайн эргээр явж олон юм үзсэн. Саппурад Зүүн азийн судлалын төвтэй холбоо тогтоов. Ер нь Монгол, Хокайдо хоёр маш ойр дотно байх учиртай юм байна гэж бодсон. Бодсноо ажил хэрэг болгох гэж зүтгэж л байна. Би ингэж л нэг жилийн дотор аз таарч Япон тэнгисийн эргийн чухал газар орон, хот сууринаар дөрвөн удаа явж үзсэн мань энэ билээ. Япон тэнгис сайхан, түүний эклогийг хамгаалах нь хүн төрөлхтний нэгэн үүрэг мөн.

### Заяруулга

54-р хуудасны эхний 5 мөрийг 55-р хуудасны 6, 7-р мөрний завсар оруулж уншина уу,